

## ӨГҮҮЛЭЛ

## Гибрид дайны “соёлын талбар”: ОХУ-Украины мөргөлдөөний жишээн дээр

Буян-Эрдэнийн Мөнхцэцэг<sup>Ⓜ</sup>

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн  
Улаанбаатар, Монгол Улс  
[btunkhtsetseg@mas.ac.mn](mailto:btunkhtsetseg@mas.ac.mn)

**Хураангуй:** 2022 онд эхэлсэн ОХУ-Украины зэвсэгт мөргөлдөөн нь уламжлалт цэргийн ажиллагааг мэдээллийн дайн, соёлын нөлөөлөл зэрэг олон талт хэрэгслүүдтэй хослуулсан гибрид дайны иж бүрэн илрэл болж байна. Энэхүү өгүүлэлд уг мөргөлдөөний хүрээнд соёл, урлагийн салбарт өрнөж буй механизм, түүний дотор мөргөлдөөнийг төлөөлсөн “Z”, “V”, “O” зэрэг үсгэн бэлгэдлийн хэрэглээ, урлагаар дамжсан суртал ухуулга, ОХУ-ын эсрэг өрнөсөн “татгалзах соёл”-ын үзэгдэл зэргийг шинжилсэн. Мөн орос, украин хэлэнд мөргөлдөөний нөлөөгөөр үүссэн шинэ үг хэллэгийн социолонгвистик утгыг авч үзэв. Судалгаанд гибрид дайны үзэл баримтлалын талаар судлаачдын гаргасан сүүлийн үеийн үр дүнгүүдийг ашигласан бөгөөд үр дүнд нь соёлын талбар нь хосолмол буюу гибрид дайнд улс төрийн нөлөөллийн бие даасан механизм болон хувирч, хоёр улсын дотоод, гадаад орчинд соёлын туйлрал, зөрчилдөөн гүнзгийрч буй нэгтгэн дүгнэсэн болно.

**Түлхүүр үгс:** ОХУ, Украин, гибрид дайн, соёл, татгалзах соёл

### Удиртгал

XXI зууны олон улсын харилцаанд зэвсэгт мөргөлдөөн улам олон талт шинжтэй болж, уламжлалт цэргийн ажиллагаа нь мэдээллийн дайн, эдийн засгийн хориг, цахим халдлага, зөөлөн хүчний стратеги зэрэг бодлогын өргөн хүрээний хэрэгслийг хамрах

болжээ. Энэ нь “гибрид дайн” хэмээх ойлголтыг баталгаажуулж, улс хоорондын зөрчилдөөн зөвхөн фронтын шугамд бус, медиа орчин, уран бүтээл, хэл, соёлын талбар зэрэг олон түвшинд зэрэг өрнөх шинэ хэлбэрт шилжиж байна. Гибрид



дайны үзэл баримтлалд нийгмийн ухамсар, үнэт зүйл, танин мэдэхүйн орчныг чиглэсэн дайтагч улсын төрөөс шууд болон шууд бус нөлөөллийн хэрэгслүүдийг нэгэн зэрэг ашиглах явдлыг онцолдог бөгөөд ийм үйл ажиллагаа нь орчин үеийн зөрчил мөргөлдөөний нэгэн зэвсэг болсон байна.

2022 онд эхэлсэн ОХУ, Украины зэвсэгт мөргөлдөөн нь гибридийн дайны томоохон жишээ мөн гэж үзэж болно. Мэдээллийн сүлжээнд сөргөлдөгч улсын иргэд бие, биенийхээ эсрэг ашиглаж буй элдэв үг хэллэг, нэршлүүд, татгалзах соёл (англи. *cancel culture*), урлагийн салбараар дамжуулсан ухуулга зэрэг олон сувагтай механизмаар уг мөргөлдөөн соёлын орон зайд хүчтэй нэвтэрч, улс төрийн байр суурь, нийгмийн туйлшрал, дайны талаарх төсөөлөл, ойлголтыг өөрчилж буй нь харагдаж байна. Үүнтэй зэрэгцэн хоёр улсын соёлын бодлого, уран бүтээлчдийн байр суурь, урлагийн бүтээлүүдийн утга агуулга богино хугацаанд эрс өөрчлөгдөж, соёл нь өөрөө гибридийн дайны нэгэн талбар буюу улс төрийн нөлөөллийн хэрэгсэл болон хувирсан нь гибридийн дайны судалгаанд шинэ, онцгой судлагдахуун болж байгаа юм.

Өнөөгийн байдлаар ОХУ, Украины мөргөлдөөний талаар дайн судлалын үүднээс гадаадад судалгааны ажил өргөн хүрээнд хийгдэж байна. Харин Монгол Улс дахь судалгааны бүтээлүүдийн ерөнхий чиг хандлага

нь геополитик, аюулгүй байдал, эдийн засгийн хориг, олон улсын эрх зүй, бүс нутгийн тогтолцоонд үзүүлэх нөлөөллийг тайлбарлахад чиглэж байна. Сүүлийн жилүүдэд, ялангуяа хоёр улсын хооронд зэвсэгт мөргөлдөөн эхэлснээс хойш Монгол Улсад гибридийн дайны талаарх судалгаа нэмэгдсэн бөгөөд ихэвчлэн мэдээллийн дайн, кибер аюулгүй байдал, стратегийн өрсөлдөөний хүрээнд төвлөрсөн хандлагатай байгаа юм. Дотоодод гибридийн дайны тухай онол, практикийн түвшний системтэй судалгаа хийгдсэн нь ХИС-ийн ОУХНСС-ийн багш, доктор (Ph.D) П.Мягмардоржийн “Орчин цагийн олон улсын харилцаа ба ‘гибридийн дайн’-ы талаар хийсэн судалгаа, үнэлэлт дүгнэлт” өгүүлэл<sup>1</sup> бөгөөд тус өгүүлэлд гибридийн дайныг цэрэг, эдийн засаг, мэдээлэл, кибер орчин зэрэг олон хэмжээсийг уялдуулсан нийлмэл үзэгдэл хэмээн онолын хүрээнд судалсан нь манай улсад уг ойлголтын суурь хүрээг тогтоож өгсөн гэж үзэхээр байна. Түүнчлэн Аюулгүй байдал судлалын хүрээлэнгээс гаргасан “Мэдээллийн дайн буюу сэтгэцэд нөлөөт үйлчлэл (Гадаадын цэрэг, тусгай албадын зарим үйл ажиллагаа ба аюулгүй байдлын тулгамдсан асуудал)” хэмээх судалгаанд<sup>2</sup> мэдээллийн дайн болон мэдээллийн сөргөлдөөнийг мэдээлэл-сэтгэлзүйн, мэдээлэл-техникийн гэх хоёр үндсэн бүлэгт хуваан ангилж, сүлжээ төвтэй дайн, гибридийн дайн

<sup>1</sup> П.Мягмардорж, “Орчин цагийн олон улсын харилцаа ба ‘Гибридийн дайн’-ы талаар хийсэн судалгаа, үнэлэлт дүгнэлт,” *Олон Улс Судлал* 46, №115 (2023): 12–27, <https://doi.org/10.5564/jis.v46i115.2686>

<sup>2</sup> Аюулгүй байдал судлалын хүрээлэн, Мэдээллийн дайн буюу сэтгэцэд нөлөөт үйлчлэл (Гадаадын цэрэг, тусгай албадын зарим үйл ажиллагаа ба аюулгүй байдлын тулгамдсан асуудал), 2020

гэх нэр томъёог гадаад улсууд дахь цэрэг, тусгай албадын практиктай холбон танилцуулсан бол мөн тус хүрээлэнгийн “Холимог дайны концепц – мэдээлэл сэтгэлзүйн талбар дахь холимог дайн” судалгааны нийтлэлд<sup>3</sup> хүний ухамсар, танин мэдэхүй, үнэт зүйлд чиглэсэн мэдээлэл-сэтгэлзүйн үйл ажиллагаа гибрид дайны шинэ төв талбар болж буйг онцолж, мэдээллийн манипуляци, олон нийтийн санаа бодолд нөлөөлөх үзэгдэл, итгэлцлийн эвдрэл зэрэг үзэгдлийг үндсэн механизм болгон тодорхойлсноор энэ чиглэл дэх дотоодын судалгаанд чухал хувь нэмэртэй болжээ.

Гибрид дайны чиглэлээр дотоодод хийгдсэн өөр нэгэн онцлох судалгаа нь ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Аюулгүй байдал, стратеги тойм” цувралын 2023 оны дугаарт нийтлэгдсэн “Орчин үеийн дайны хувьсал өөрчлөлт, зэвсэглэл, техникийн хөгжил” судалгааны нийтлэл<sup>4</sup> бөгөөд ОХУ, Украины мөргөлдөөнийг зэвсэгт мөргөлдөөний шинэ үеийн шинж чанарыг хамгийн тод илэрхийлсэн жишээ хэмээн үзэж, мэдээллийн дайн нь дэлхий нийтийг талцуулах хэмжээнд хүрч, геостратегийн өрсөлдөөн, эрчим хүчний нөөц, их гүрнүүдийн нөлөөллийн бодлого зэрэг уламжлалт улс төр-цэрэг стратегийн шалтгаануудтай хавсарсан өгөгдөл, кибер, сэтгэлзүйн довтолгоо зэрэг

хэлбэрээр өрнөн, уламжлалт хүчнээс гадна мэдээллийн манипуляци зэрэг дэвшилтэт технологи уг дайнд өргөнөөр ашиглагдах болсноор “байлдааны талбарт ялалт байгуулах” ба “дайнд стратегийн утгаар ялалт байгуулах” хоёр ялгаатай ойлголт дайн судлалд бий болж буйг онцолсон нь гибрид буюу хосолмол дайны ойлголтыг гүнзгийрүүлэн шинжилсэн ач холбогдолтой судалгаа болсон байна.

Харин гибрид дайны “соёлын талбарт” өрнөж буй сөргөлдөөнийг авч үзсэн судалгаа одоогоор дотоодын хэмжээнд төдийлэн хийгдээгүй байна. Судлаачийн зүгээс соёлын талбарт өрнөж буй эл сөргөлдөөн нь нийгмийн сэтгэлгээний төлөвшилд нөлөөлөх, эсэргүүцлийн арга хэлбэрийг тодорхойлох, улмаар улс орнуудын зөөлөн хүчний чадавхыг өөрчлөх зэрэг үндсэн механизмуудыг агуулдаг тул гибрид дайны орчин дахь нэгэн чухал судлагдахуун гэж үзэх үндэслэлтэй хэмээн дүгнэж байна. Иймд тус өгүүлэлд ОХУ, Украины мөргөлдөөний “соёлын талбар” дахь сөргөлдөөнийг үсгэн бэлгэдэл, урлагийн салбарт явагдаж буй суртал ухуулга, ОХУ-ын түрэмгийллийг эсэргүүцсэн татгалзах соёлын үзэгдлээр жишээ аван шинжлэхийн сацуу мөргөлдөөний үед орос, украин хэлэнд нэвтэрсэн шинэ хэллэгүүдийн социоллингвистик утгыг авч үзсэн бөгөөд судалгааны зорилго нь соёлын хэрэгслүүд хэрхэн улс төрийн

оны 5 дугаар сарын 15, <https://niss.gov.mn/мэдээллийн-дайн-буюу-сэтгэцэд-нөлөөт/>

<sup>3</sup> Аюулгүй байдал судлалын хүрээлэн, “Холимог дайны концепц – мэдээлэл сэтгэлзүйн талбар дахь холимог дайн (I), 2024 оны 10 дугаар сарын 4, <https://niss.gov.mn/холимог-дайны-концепц-мэдээлэл-сэтгэ/>

<sup>4</sup> ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн, Стратеги тойм №16: “Сүүлийн үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, онцлог” (Улаанбаатар: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэн, 2023), 1–20.

нөлөөллийн бодит механизм болж, соёлын туйлшрал, зөрчилдөөн үүсгэж хоёр улсын дотоод болон гадаад орчинд буйг тайлбарлахад чиглэлээ.

### Нэг. Онолын хэсэг

Гибрид буюу хосолмол дайн хэмээх ойлголтыг олон улсын харилцаа судлаачид XXI зууны олон улсын зөрчил, мөргөлдөөний хэлбэрүүдийн хувьсал, өөрчлөлтийг тайлбарлахад өргөнөөр ашиглах болсон бөгөөд түүний мөн чанар нь уламжлалт хүчний хэрэгслийг уламжлалт бус хүчний хэрэгслийн хамтаар хослуулан хэрэглэхэд оршдог. Өөрөөр хэлбэл, зөвхөн зэвсэгт хүчин, террорист халдлага зэргээс гадна, мэдээллийн манипуляц хийх замаар олон нийтийн санаа бодолд нөлөөлөх “зөөлөн хүч”-ний арга, хэлбэрийг уялдуулсан цогц стратеги аж. Иймд гибрид дайн нь фронтын шугамд өрнөх зөрчилдөөнийг нийгмийн ухамсар, үнэт зүйл, танин мэдэхүйн талбарыг хамран явагддаг хэмээн тодорхойлогддог. Гибрид дайны үзэл баримтлалын үндсэн утга нь нийгмийн оюун санааны орон зайг хяналтдаа авах явдал байдаг. Хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтийн санаа бодолд нөлөөлөх нь дайтагч улсын зүгээс эсрэг талын дотоод тогтвортой байдал, итгэлцэл, нийгэм дэх эв нэгдлийг сулруулж, өөрийн талын үйл ажиллагааг зөвтгөх зорилготой юм. Иймд гибрид дайн нь дайтагч улсуудын нийгмийн сэтгэлгээ, хэл, соёл уран бүтээл, онлайн харилцааны хэв маягт үлэмж

нөлөөлдөг бөгөөд соёл нь өөрөө стратегийн талбар болон хувирдаг ажээ.

Гибрид дайнд ашиглагдах арга хэрэгслүүдийн талаар дэлгэрүүлэн авч үзсэн сүүлийн үеийн судалгааны ажлуудад “соёлын фронт” нь стратегийн чухал орон зай болдгийг дурджээ. Тухайлбал, Европын Комиссын Судалгааны нэгдсэн төв болон Гибрид аюултай тэмцэх Европын төвөөс хамтран гаргасан “The Landscape of Hybrid Threats: A Conceptual Model” (*Гибрид аюулын орчны зураглал: Үзэл баримтлалын загвар*) тайланд гибрид дайны хүрээнд соёлын орон зайг стратегийн бие даасан нэгэн “домэйн” буюу салбар хэмээн тодорхойлж, нийгмийн үнэт зүйлээр дамжуулан олон нийтийн ухамсарт системтэйгээр нөлөөлөхийг зорьдог<sup>5</sup> хэмээсэн байна. Түүнчлэн Британийн Зөвлөлөөс гаргасан “Soft power, cultural relations and conflict through Eurovision and other mega-events” (“*Eurovision*” болон бусад томоохон соёлын арга хэмжээнүүд дэх соёл, зөөлөн хүчний харилцаа, мөргөлдөөн) судалгаанд дүгнэснээр соёлын дипломат ажиллагаа, олон улсын томоохон арга хэмжээнүүд нь зэвсэгт мөргөлдөөний үед улс орнуудын геополитикийн байр суурь,

<sup>5</sup> Cullen, P., Juola, C., Karagiannis, G., Kivisoo, K., Normark, M., Rácz, A., Schmid, J. and Schroeffer, J., The landscape of Hybrid Threats: A Conceptual Model (Public Version) [*Гибрид аюулын орчны зураглал: Үзэл баримтлалын загвар*], Giannopoulos, G., Smith, H. and Theodoridou, M. editor(s), EUR 30585 EN, Publications Office of the European Union, Luxembourg, 2021, ISBN 978-92-76-29819-9, doi:10.2760/44985, JRC123305.

эсэргүүцлийн илэрхийлэл болон олон улсын эв санааны нэгдлийг тодорхойлогч стратегийн талбар болж хувирдаг гэжээ.

Мөн Украины судлаачид энэ талаар цөөнгүй судалгаа хийсэн бөгөөд судлаач Александр Лытвыненкогийн 2024 онд бичсэн өгүүлэлд ОХУ-ын олон улсын тавцан дахь зөөлөн хүчний стратегид соёл, хэл, түүх, хэвлэл мэдээлэл зэрэг хэрэгсэл шийдвэрлэх байр суурь эзэлдгийг онцолж, эдгээр нь бүс нутгийн улс орнуудын дотоод орчин, улс төрийн чиг баримжааг өөрчлөх геополитикийн зорилготой уялддаг хэмээн дүгнэсэн бөгөөд энэ нь гибрид дайнд “соёлын фронт” нь аливаа улс зөвхөн өөрийгөө хамгаалаад зогсохгүй нөлөөгөө тэлэх стратегийн хэрэгсэл болсныг харуулж байна. ОХУ-ын явуулж буй гибрид дайны түрэмгийллийн хүрээнд Украин Улсын

хэрэгжүүлж буй соёлын бодлогын талаар мөн онд нийтлэгдсэн өөр нэгэн судалгаанд Украин Улс 2014 оноос хойш соёлын бодлогоо үндсээр нь шинэчилж, Оросын мэдээлэл-сэтгэлзүйн нөлөөллийг саармагжуулах, дотоодод үндэсний дархлаа, түүхэн үнэнийг хамгаалах зорилгоор соёлын салбарыг тус улсын аюулгүй байдлын бодлогын бүрэлдэхүүн хэсэг болгон хөгжүүлсэн талаар өгүүлжээ. Иймд гибрид түрэмгийлэлд өртсөн үед аливаа улсын соёлын бодлого төрийн аюулгүй байдлын үндсэн тулгуурын нэг болдог байна.

Ингэснээр гибрид дайны онолын хүрээнд соёлын талбар нь мэдээлэл, хэл шинжлэл, бэлгэдлийн дайн, зөөлөн хүч болон танин мэдэхүйн дайн (cognitive warfare)-ийн огтлолцолд орших үндсэн стратегийн механизм гэж үзэх боломжтой байна.

## Хоёр. Үндсэн хэсэг

### 2.1. ОХУ-ын түрэмгийллийг төлөөлсөн үсгэн бэлгэдлийн агуулга, хэрэглээ

ОХУ Украины нутаг руу түрэмгийлж, дайн дэгдээсний дараа хоёр улсын хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, иргэдийн дунд “Z”, “Y”, “O” гэсэн латин үсэгнүүд Украины эсрэг ОХУ-ын түрэмгийллийг төлөөлсөн тэмдэг болсон бөгөөд эдгээрийг ОХУ-ын цэргийн техник болон зэвсэгт мөргөлдөөнийг дэмжсэн суртал ухуулга хийхэд одоогоор ихээхэн ашиглаж байна.

2022 оны хоёрдугаар сард буюу

мөргөлдөөн эхлэхээс долоо хоногийн өмнө олон улсын хэвлэлүүдэд ОХУ-ын техник дээр “Z”, “V”, “O”, “X”, “A” гэсэн латин үсгүүд бичигдсэн талаарх анхны мэдээлэл<sup>6</sup> гарч эхэлсэн. Эдгээр үсгийг хэрэглэх болсон шалтгааныг судлаачдын зүгээс а. галд өртөхөөс зайлсхийх зурвас, б. баруун, зүүн цэргийн тойрог (орос. западный, восточный), в. ОХУ-ын довтлох бүсийг илэрхийлж буй<sup>7</sup> зэрэг ялгаатай байдлаар тайлбарлаж байгаа

<sup>6</sup> BBC. “Переброска войск, поставки оружия и эвакуация из посольств. Как развивается ‘украинский кризис’.” January 24, 2022. <https://www.bbc.com/russian/news-60077654>

<sup>7</sup> Robyn Dixon. “The letter ‘Z’ has become a symbol of Russia’s war.” *The Washington Post*, March 9, 2022. <https://www.washingtonpost.com/world/2022/03/09/letter-z-russia-symbol-pro-war/>

юм. Харин ОХУ-ын Батлан хамгаалах яамны зүгээс эдгээр тэмдэгт ямарваа нэгэн тусгай утга агуулаагүй<sup>8</sup> хэмээн мэдэгдэж байв.

Улмаар 2022 оны хоёрдугаар сарын сүүл, гуравдугаар сарын эхээр ОХУ-ын түрэмгийллийг дэмжихэд “Z” болон “V” үсгүүдийг ихээхэн хэрэглэх болов. ОХУ-ын эрх баригчид “Z” флэшмобыг ивээн тэтгэж, уг үсэг бүхий тэмдэгтийг хүмүүс хувцас, барилга, тээврийн хэрэгсэл дээр наах байдлаар хэрэглээнд нэвтрүүлж, тус үсгийг ашиглахыг эсэргүүцэж байсан хүмүүсийн эсрэг эрүүгийн хэрэг хүртэл үүсгэж байсан<sup>9</sup> мэдээлэл байна. 2023 оны эхээр “Z”, “V” үсгийг хэрэглээ хумигдаж, зөвхөн дайныг дэмжигч тэрс үзэлтнүүд л ашиглах болсон бол оны төгсгөлд Украинд дайтаж буй эр нөхөр, төрөл төрөгсдөө буцаан авчрахыг шаардсан эмэгтэйчүүд флэшмобдоо эдгээр үсгийг ашиглаж байсан юм.

Түүнчлэн хоёр улсын хилийн орчимд ОХУ-ын цэргийн техникүүд олноор байршсан талаарх мэдээлэл 2022 оны нэгдүгээр сараас эхлэн гарсан бөгөөд хоёрдугаар сарын 19-ний өдөр буюу түрэмгийлэл эхлэхээс тав хоногийн өмнө танк болон цэргийн машинууд дээр “Z” үсгийг будгаар бичсэн талаарх мэдээлэл анх цацагдаж

байв. “Z” үсгийг танк, ачааны машин зэрэг цэргийн техникүүд дээр цагаан будгаар зурж байлаа. Улмаар үүний араас “V”, “O”, “X”, “A” үсгүүд гарч ирэв. Олон улсын хэвлэлүүдэд гарсан мэдээнүүдийг шүүн үзэхэд чухамхүү “Z” үсэг бүхий техникүүд Украины хилийг анхлан давсан болохыг илрүүлжээ<sup>10</sup>.

Ийнхүү түрэмгийлэл эхэлснээс хэд хоногийн дараа “Z”, “V” үсгүүдийг түрэмгийллийн албан ёсны илэрхийлэл буюу тэмдэг<sup>11</sup> гэж нийтээр хүлээн авах болжээ. Гэхдээ эдгээр үсгийг чухам ямар утгаар хэрэглэж эхэлсэн нь одоог хүртэл тодорхойгүй байгаа юм. 2014 оноос эхлэн ОХУ, Украины зөрчилдөөнийг судалж буй “Bellingcat” нээлттэй эх сурвалжид тулгуурласан мөрдөн шалгах төвийн судлаач А.Толер “өмнө нь ийм төрлийн тэмдэгтэй огт таарч байсангүй”<sup>12</sup> гэж онцолсон байдаг. Өрнөдийн шинжээчид “тус латин тэмдэг нь өөрийн талын галаас зайлсхийхийн тулд ашиглах, дэлхийн хоёрдугаар дайны үед ашиглаж байсан арга” гэдэг дээр санал нэгдэж байна<sup>13</sup>. Гэхдээ алсын зайнаас хангалттай харагдахуйц хэмжээтэй биш учир өөрийн талын галаас зайлсхийх арга биш, харин латин үсгүүд нь анхны байршил эсвэл хөдөлгөөний

<sup>8</sup> Мөн тэнд

<sup>9</sup> Andrew Roth, “Russian Court Jails Man for Replacing Price Tags with Antiwar Messages,” *The Guardian*, April 8, 2022, <https://www.theguardian.com/world/2022/apr/08/russian-court-jails-antiwar-messages>

<sup>10</sup> Мөн тэнд

<sup>11</sup> Shaun Walker, “Russia’s War Symbol ‘Z’ Fades from Public View,” *The Guardian*, January 16, 2023, <https://www.theguardian.com/world/2023/jan/16/russia-war-symbol-z-fades-from-public-view>

<sup>12</sup> Aric Toler. “Identifying the Russian Invasion Force.” Bellingcat, February 23, 2022. <https://www.bellingcat.com/news/2022/02/23/identifying-the-russian-invasion-force/>

<sup>13</sup> Jeff Schogol, “Here’s What Those Mysterious White ‘Z’ Markings on Russian Military Equipment May Mean,” *Task & Purpose*, March 9, 2022. <https://taskandpurpose.com/news/russian-military-equipment-white-markings/>



чиглэлийг илтгэхэд зориулагдсан гэж зарим шинжээчид үзэж байгаа юм. Түүнчлэн эдгээр үсгүүд нь цэргийн тойргийг илтгэх, тухайлбал, “Z” нь “Западный военный округ” (Баруун цэргийн тойрог), “V” нь “Восточный военный округ” (Зүүн цэргийн тойрог), гурвалжин дүрс нь “Южный военный округ” (Өмнөд цэргийн тойрог) гэж тайлбарласан байх ба дөрвөлжин дүрс доторх “Z” үсэг нь Крымийн цэргүүд, “O” нь Беларусийнх, “X” нь Чеченийн цэргүүд харин “A” нь тусгай албаныхан хэмээн тайлбарласан нь ч байна<sup>14</sup>.

Сүүлийн хувилбарыг нотлох баримт гэвч олдоогүй юм. Тухайлбал, Чеченийн отрядын техник дээр “V” үсэг дүрсэлсэн байсан нь дээрх таамаглал эргэлзээтэй гэдгийг харуулж байна.

Сүүлд ОХУ-д латин цагаан толгойн “Z” үсгийг “За победу”, “За наших” гэх зэргээр кирилл цагаан толгойн “З” үсгийг орлуулахын тулд ашиглаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, “З”-г “Z” үсгээр орлуулснаар илүүтэй “эх оронч” утгыг агуулж байгаа гэж үзэхээр байна. Улмаар тус улсад эх оронч үзэл санааг шингээхийн тулд “Z” үсгийг георжийн туузаар чимэглэхтэй олонтаа таарч байна. ОХУ-ын сөрөг хүчнийхний хувьд энэ нь сөрөг утга агуулах бөгөөд “Z” хөгжим, “Z” үзэл суртал, “Z” гоозүй, “Z” дуучид зэргээр ОХУ-ын талын суртал ухуулгыг дэмжиж байгаа уран бүтээлчид болон тэдний бүтээл

туурвилыг нэрлэх болсон юм.

Латин цагаан толгойн энэ үсгийг ийнхүү дайн дэмжсэн суртал ухуулгад хэрэглэх болсон тул Эстони, Украин, Молдав, Литва, Латви, Германы зарим мужуудад ОХУ-ын армийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Z” үсгийг олон нийтийн дунд дүрслэн харуулахыг хориглосон байна.

Эдгээр үсгүүдийг улмаар ОХУ-ын Батлан хамгаалах яам албан ёсны хаягуудаараа дамжуулан ашиглах болжээ. Тухайлбал, 2022 оны гуравдугаар сарын гуравны өдөр Инстаграм хуудсандаа “За победу”, “За мир”, “Сила V правде”, “Zakam нацизма” (“Ялалтын төлөө”, “Энхийн төлөө”, “Үнэнд хүч оршино”, “Нацизмын эсрэг”) гэх зэргээр ашиглаж эхэлсэн юм. Улмаар тавдугаар сарын 26-ны өдөр ОХУ-ын гвард “Цэргийн тусгай ажиллагааны оролцогч” гэсэн медаль гаргасан бөгөөд энэ медалийн нүүрэн талд “Zет” үсэг хэлбэртэй туузны наана автомат барьсан цэргийн алба хаагчийг дүрсэлжээ.

АНУ-ын Стратеги, олон улс судлалын төвийн судлаач Мария Снеговагийн үзэж байгаагаар, улбар шар, хар өнгөтэй Z үсэг нь өнөөгийн халдан довтоллт ба Дэлхийн хоёрдугаар дайны ялалт хоорондын уялдаа холбоог үүсгэхийн сацуу “түүхэн ялагч” гэх ОХУ-ын үндэсний үзэл санааг дэмжиж байна гэж үзсэн<sup>15</sup>. Харин Зөвлөлтийн түүхч Алексей

<sup>14</sup> Алексей Ковалев. “Буква Z — официальный (и зловецкий) символ российского вторжения в Украину.” *Meduza*, March 15, 2022. <https://meduza.io/feature/2022/03/15/bukva-z-ofitsialnyy-i-zloveschiy-simvol-rossiyskogo-vtorzheniya-v-ukrainu-my-popytalis-vyyasnit-kto-eto-pridumal-i-vot-chto-iz-etogo-poluchilos>

<sup>15</sup> Paula Villegas, “How ‘Z’ Became a Symbol for Supporting Russia’s Invasion of Ukraine,” *The Washington Post*, March 9, 2022.

Новиков Z үсгийг “ард түмэн” гэх ойлголттой дүйцүүлж байлаа.

“Үнэн хэрэгтээ “Z” үсэг нь латин үсэг биш, харин эртний грекээс гаралтай. X-XI зуунаас манайд ашиглагдаж байгаа. “Z” бол газар гэсэн утгатай (орос хэлээр - “земля”).

Ингэж л нэрлэгдсээр ирсэн. Түүнчлэн “ард түмэн” гэсэн утга ч агуулж байсан. Киевийн Оросоос Новгород, Владимирск хүртэл үүнийг ашиглаж байсныг түүхэн олон сурвалж гэрчилдэг” хэмээн өгүүлж байв<sup>16</sup>.

## 2.2. Урлагийн салбар дахь сөргөлдөгч талуудын суртал ухуулгыг шинжлэх нь

Гибрид дайны үзэл баримтлал дэлгэрэхээс ч өмнө олон улсын харилцаанд улс орнууд аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөний үеэр олон нийтэд нөлөөлөхийн тулд урлагийг суртал ухуулгын хэрэгсэл болгон ашиглаж ирсэн түүхтэй билээ. ОХУ-Украины мөргөлдөөн ч ийм замыг туулж байгаа юм. Урлагаар дамжуулсан суртал ухуулга нь дуу хөгжим, кино урлаг, утга зохиол гэсэн гурван салбарт илэрч байна.

Мөргөлдөөн эхэлснээс хойш ОХУ-д урлаг соёлын томоохон арга хэмжээ олон зохиогдсон. Украинд үргэлжлүүлж буй ОХУ-ын цэргийн ажиллагааг дэмжсэн хамгийн алдартай, шуугиан тарьсан соёлын арга хэмжээ нь “За Россию”<sup>17</sup> марафон юм. Бүс нутгуудаар тойрон зохион байгуулагдсан энэ аялан тоглолтод цэрэг, эх оронч дуугаараа алдартай Любэ хамтлагийн ахлагч Николай Расторгуев, алдарт дуучин Дмитрий Певцов, “Уматурман”, “Пилот”, “Самоцветы” хамтлагууд, мөн л эх оронч үзэл санаа бүхий дуугаараа

алдартай ОХУ-ын дуучин Олег Газманов тэргүүтэн олон алдартан оролцож байв.

ОХУ-ын поп хөгжмийн одод хуучин дуугаа сэргээн дуулсан аялан тоглолтоор хязгаарлагдажгүй, өнөөгийн мөргөлдөөний сэдэвтэй шинэ уран бүтээл ч туурвисан юм.

Тэдгээрийн дунд найман жилийн өмнөөс л өөрсдийгөө тунхагласан Луганск, Донецк бүгд найрамдах улсуудыг дэмждэг уран бүтээлчид багтаж байсны нэг нь Юлия Чичерина юм. Тэрээр 2015 оноос Луганск руу явах болж улмаар 2017 онд Луганскийн иргэншилтэй болжээ. Улмаар 2016 онд “Тэргүүн шугаманд” нэртэй клип гаргасан нь босогчдын албан бус сүлд дуу болсон юм. Үүний араас “Линия спарта”, “Сайн дурынхан”, “Улаан арми бүхнээс хүчтэй”, “ОХУ-ын ой”, “Донбасс” зэрэг уран бүтээлүүд гаргаж байлаа.

Өөр нэгэн Юта хэмээх рок дуучин ОХУ-ыг Сирид ажиллагаа явуулснаас эхлэн Оросын армийг дэмжиж, үүнийхээ төлөө медаль хүртэж байсны

<sup>16</sup> Виталий Мягкий. “Историк рассказал об истинном значении букв Z и V для России.” *URA.RU*, March 17, 2022. <https://ura.news/news/1052539321>

<sup>17</sup> “Марафон ‘За Россию’ обошелся почти в 100 миллионов рублей из бюджета...” *Meduza*, May 11, 2022. <https://meduza.io/feature/2022/05/11/marafon-za-rossiyu-oboshelsya-pochti-v-100-millionov-rublej-iz-byudzheta-ego-organizoval-ekspertnyy-institut-dalekiy-ot-shou-biznesa-no-blizkiy-k-kremlyu>



дээр 2016 онд ОХУ-ын төлөө уран бүтээл гаргаж байсан юм. Харин 2022 онд гаргасан “За жизнь” нэртэй дуу нь ОХУ-ын армийн анги нэгтгэлүүдийн сүлд дуулал болсон<sup>18</sup> ажээ.

ОХУ-ын бусад уран бүтээлчид мөн 2022 оны хоёрдугаар сараас хойш тасралтгүй эх оронч сэдэвтэй уран бүтээл туурвисны дотор Вика Цыгановагийн “Вагнер” хэмээх дуу ихээхэн алдаршсан юм. “Алив Вагнер, тоглоорой, хөгжимчдөө босгоорой” хэмээн дуулах энэ дуу ОХУ-ын хувийн цэргийн компани болох Вагнерын сүлд дуу болжээ. Үүний зэрэгцээ Оросын хуучны эх оронч агуулга бүхий дуунууд ч шинэ агуулгаар дахин дуулагдах болсон юм. Үүний нэг нь ОХУ-ын дуучин Олег Газмановын “Офицерууд” дуу бөгөөд мөргөлдөөн эхэлснээс хойш энэ дууг ашиглан төрөл бүрээр дүрсжүүлсэн хувилбарууд олноор цацагджээ. Газманов улсынхаа эх оронч бусад уран бүтээлчдийн адилаар Донбасст тоглолт хийж, 50 мянган үзэгчийг цуглуулж байв. Соёлын ийм арга хэмжээг ОХУ-ын Засгийн газраас өндөр дүнгээр ивээн тэтгэдэг ба тухайлбал, Газмановт Донбасст хийсэн тоглолтод нь зориулж 17 сая рублийн шан өгсөн гэх мэдээлэл Өрнөдийн хэвлэлээр гарч байсан ч дуучин өөрөө үүнийг үгүйсгэж байв<sup>19</sup>.

Зэвсэгт мөргөлдөөн эхэлсний дараа Украинд ОХУ-ын хүчийг эсэргүүцэн зогсох бэлгэ тэмдэг болсон хоёр дуу

ихээхэн алдаршсан. Үүний нэг нь “5низза” хамтлагийн гишүүн асан Сергей Бабкины “Цэрэг” дуу юм. Нөгөө нь “Бумбокс” хамтлагийн ахлагч Андрей Хлывнюкийн дуулсан “Червона Калына” гэх ардын дуу юм. Тэрээр мөргөлдөөн эхлэх үед АНУ-д хамтлагийнхантайгаа аялан тоглолт хийх явцдаа тоглолтоо дуусгаад Украины зэвсэгт хүчинд элсэх шийдвэр гаргасан<sup>20</sup>. Ингээд дайчин эрсийн урам зоригийг сэргээх үүднээс автомат буу үүрч, гудамжинд зогсож байгаад энэ дууг дуулсан байна. Улмаар Их Британийн “Пинк Флойд” хамтлаг түүнтэй холбогдон Червона калына дууг түшиглэн “Hey, Hey, Rise Up” дуу бүтээсэн нь 12 сая гаруй хандалт авсан үзүүлэлттэй байна. Энэ дуу Украины зэвсэгт хүчин төдийгүй Украины армийг дэмждэг иргэдийн дунд ихээхэн алдаршсан юм.

Түүнээс гадна “Раммштайн”, “Билли Айлиш”, “Скорпионс” зэрэг алдартай хамтлаг, дуучид Украины армийг дэмжиж уран бүтээл гаргасан нь энгийн иргэдийн дунд украинчуудыг дэмжих хандлагыг нэмэгдүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

#### *а. Утга зохиолын салбарт*

Утга зохиолын салбарт суртал ухуулгын шинжтэй уран бүтээл туурвих болсон. Мөн л “Z” үсгийг ашиглан “Z” (Зет) яруу найраг гэх урсгал бий болсон бөгөөд үүнийг

<sup>18</sup> Юта [Анна Владимировна Осипова], “Премьера песни: «За жизнь»,” *RT на русском*, November 29, 2022, <https://russian.rt.com/russia/video/1080146-premera-pesni-yuta-za-zhizn>

<sup>19</sup> *Moika78*. “Певец Олег Газманов отрицает получение 17 млн рублей за каталог патриотических песен.” February 4, 2023. <https://moika78.ru/news/2023-02-04/852047-pevets-oleg-gazmanov-otritsaet-poluchenie-17-mln-rublej-za-katalog-patrioticheskikh-pesen/>

<sup>20</sup> Andriy Khlyvnyuk, “Ой у лузі червона калина (Oh, the Red Viburnum in the Meadow),” Instagram video posted February 27, 2022, <https://www.instagram.com/p/Cae5TydPAxh/>

“Z орос зуны яруу найраг” нэртэй эмхэтгэлтэй холбоотой дуулианаас үүдэн олон нийт мэддэг болсон юм<sup>21</sup>. ОХУ-ын Засгийн газраас санхүүждэг “Russia Today” олон улсын сувгийн редакциас бэлтгэсэн энэ эмхэмтгэлийн нэрэнд “Z” үсэг орсны улмаас ОХУ-ын олон хэвлэлийн газар хэвлэхээс татгалзаж байсан нь ихээхэн шуугиан дэгдээсэн. Энэ эмхэтгэлд Донбассын оршин суугч Анна Ревякина, цэргийн сурвалжлагч Семен Пегов, цэргийн сурвалжлагч, яруу найрагч Анна Долгарева нарын олон хүний бүтээл багтсан байна. Шүлгийн эмхэтгэлийг фронт дээр байгаа эрчүүдийг сэтгэл санаагаар дэмжих, олон нийтэд эх оронч шүлгүүдийг хүргэх зорилгоор бэлтгэсэн хэмээжээ<sup>22</sup>.

“Z” яруу найраг” нь олон өнгө аястай байна. Зарим шүлэг нь Украинаас салан тусгаарласан бүс нутгуудын оршин суугчид найман жилийн өмнө бичсэн шүлгүүд байгаа бол зарим найрагчид өнөөгийн мөргөлдөөнийг “Аугаа их Эх орны дайн”-ы үргэлжлэл мэтээр дүрслэн бичжээ<sup>23</sup>.

Украин дахь мөргөлдөөнтэй холбоотой сэдвээр дуу шүлэгнээс өөрөөр томоохон хэлбэрийн уран зохиолын бүтээл гараагүй. “Түүхэн цаг үетэй холбоотой тууж, роман зэрэг аливаа томоохон хэлбэрийн бүтээл

гарахад цаг хугацаа шаардлагатай, одоогоор маш богино хугацаа өнгөрсөн”<sup>24</sup> гэж ОХУ-ын урлагийн шүүмжлэгч Константин Мильчин “RTVI” сувагт өгсөн ярилцлагадаа онцолсон байна.

Гэхдээ чухамхүү утга зохиолын салбар ОХУ-ын Батлан хамгаалахын яамны онцгой анхаарлын төвд байгаа гэдгийг онцлох хэрэгтэй. 2022 оны зун буюу ОХУ Украины нутаг руу дайснаас хэдхэн сарын дараа ОХУ-ын Батлан хамгаалах яам Армийн тэмцээн зохион байгуулж, “гар зураг”, “яруу найраг”, тууж, жүжиг төрлөөр 20 гаруй зохиолчийг шалгаруулан шагнаж<sup>25</sup> байв.

#### *б. Кино урлагийн салбарт*

Украинд болж буй цэргийн ажиллагааны тухай уран бүтээлийг төрөөс захиалахгүй байгаа талаар кино салбарынхан өгүүлж байв. Энэ нь юуны өмнө нэгдүгээрт, мөргөлдөөний тухай түүхийн утга учрыг ухаарах, эргэцүүлэх хэмжээний хангалттай цаг хугацаа өнгөрөөгүйтэй холбоотой, хоёрдугаарт, хэрэв ямарваа нэгэн үйл явдлын талаар кино бүтээвэл “худал, хуурмаг”-т тооцогдох эрсдэлтэй тул одоогоор энэ сэдвийг сонгох хүсэлтэй хүн байхгүй хэмээн нэрээ нууцалсан шинжээч “RTVI” сувагт<sup>26</sup> тайлбар өгчээ.

<sup>21</sup> “Сборник ‘Z’...” *RIA Novosti*, May 11, 2023. <https://ria.ru/20230511/sbornik-1871098248.html>

<sup>22</sup> Мөн тэнд

<sup>23</sup> *RIA Novosti*. “Сборник ‘Z’ представили в Луганске.” May 11, 2023. <https://ria.ru/20230511/sbornik-1871098248.html>

<sup>24</sup> RTVI. “Искусство без ненависти: Как конфликт России и Украины отразился в культуре обеих стран.” RTVI.com. <https://rtvi.com/stories/iskusstvo-bez-nenavisti-kak-konflikt-rossii-i-ukrainy-otrazilsya-v-kulture-obeih-stran/>

<sup>25</sup> Мөн тэнд

<sup>26</sup> Мөн тэнд

Эрх баригчдын зүгээс ОХУ-Украины мөргөлдөөнтэй холбоотой кино захиалгыг ил болон далд хэлбэрээр хийгээгүй, гэхдээ Мариуполийг эзлэсэн тухай бүрэн хэмжээний киноны зураг авалт хийгдэж буй ба одоогоор эрэлтэй байгаа цорын ганц төрөл нь байлдааны ажиллагааны талаарх баримтат кинонууд бөгөөд эдгээрийг эсвэл захиалгаар эсвэл телевизийн сувгууд худалдан авах гэрээтэйгээр хийж

байгаа гэсэн мэдээлэл байна. Эндээс үзэхэд, ОХУ-Украины мөргөлдөөний үед дуу хөгжим, утга зохиол, кино урлаг зэрэг урлагийн голлох салбарууд аль, аль талд стратегийн нөлөөний хэрэгсэл болон ашиглагдаж, нэг талаас түрэмгийллийг зөвтгөх эх оронч бүтээлүүдийг түлхүү гаргаж буй бол, нөгөө талд түүнийг эсэргүүцэж, эв нэгдлийг урлагийн хэлээр илэрхийлэх замаар соёлын талбар дахь нэгэн “зэвсэг” болж хувирчээ.

### 2.3. ОХУ-ын эсрэг “татгалзах соёл”-ын хэрэглээ

ОХУ-Украины мөргөлдөөний үеэр ОХУ-ын урлагийн эсрэг татгалзах соёл ихээр ашиглаж байна. Тус соёл нь АНУ, Европт үүссэн нийгэм улс төрийн томъёолол бөгөөд онлайн орчин, олон нийтийн сүлжээ болон бодит байдал дээр тухайн хүн эсвэл тодорхой бүлэг дэмжлэг авахгүй, шүүмжлэлийн бай болохыг хэлж байна. Кембрижийн толь бичигт “татгалзах соёл” гэдэг нь таныг доромжилж буй үйлдэл эсвэл үг хэллэгийнх нь улмаас хэн нэгнийг дэмжихээ бүрэн зогсоож буй, олон нийтийн сүлжээнд, нийгэмд эсвэл бүлэгт илрэх зан байдлын хэв маяг”<sup>27</sup> гэж тодорхойлжээ. Харин АНУ-ын Харвардын их сургуулийн профессор П.Норрис татгалзах соёлыг “нийгмийн хэм хэмжээг зөрчсөнийх нь төлөө хэн нэгнийг үл хайхрах оролдлого” гэж тодорхойлсон байдаг. Дэлхийн олон оронд энэ соёл нь хэрэглэгчид таагүй үзэгдлийг үл хүлээн авч, бойкотлох байдлаар илэрдэг. Тухайлбал, аливаа

компанийн үйл ажиллагаа нь ажилтнууд болон хүрээлэн буй орчинд ёсзүйгүй байдлаар чиглэгдсэн бол хэрэглэгчид тухайн компанийг бойкотлож, улмаар борлуулалт нь буурдаг.

Татгалзах соёл нь түүнчлэн “соёлын бойкот” гэдэг утгаар ашиглагддаг. Чухамхүү энэ утгаараа ОХУ-ын урлагийн эсрэг ашиглагдаж байгаа юм. “Оросоос татгалзах үзэгдэл” нь олон улсын түвшинд “татгалзах соёл”-ын илрэл болон гарсан. ОХУ 2022 оны хоёрдугаар сарын 24-ний өдөр Украин руу халдан довтолсны дараа олон улсын зүгээс олон хориг тавьсны зэрэгцээ урлаг соёлоос нь татгалзах давлагаа эхэлсэн юм.

Мөргөлдөөн эхэлсний дараа ОХУ-ын урлагийнхны эсрэг татгалзах соёлын давалгаа эхэлсэн бөгөөд Евровишн, Каннын Кино наадмаас хасаж, ОХУ-ын Их театр ч гадаадын бусад томоохон театруудтай хамтран ажиллахаа больж, ОХУ-ын алдартай

<sup>27</sup> Л. Р. Рустова и Д. Г. Иванова. “Культура отмены в отношении России и способы борьбы с ней.” *CyberLeninka*. <https://cyberleninka.ru/article/n/kultura-otmeny-v-otnoshenii-rossii-i-sposoby-borby-s-ney/viewer>

удирдаачид гадаад дахь гэрээгээ цуцлуулж байлаа. Мөн ОХУ-ын хөгжимчдийн бүтээлийг томоохон театрууд урийн сангаасаа хасаж байв.

Мөргөлдөөн гарсны дараа хоёр тал аль аль нь урлаг соёлынхны бүтээлийг бойкотолж, Украинд ерөнхий боловсролын уран зохиолын А.С.Пушкин, И.А.Крылов, А.П.Чехов, И.С.Тургенев, И.А.Бунин, С.А.Есенин, М.А.Шолохов, Б.Л.Пастернак, В.В.Маяковский, А.А.Ахматова, Н.С.Гумилев, М.И.Цветаева нарын нийт дөчин орос зохиолчийн бүтээлийг сургалтын хөтөлбөрөөс хасжээ. Сөргөлдөгч талууд нэгнийхээ соёлоос ийнхүү татгалзахыг хүлээн зөвшөөрч болох ч хачирхалтай гэмээр үйл явдлууд ч гарсан юм. Тухайлбал, Миланы их сургууль Достоевскийн бүтээлийг их сургуулийн хөтөлбөрөөс хассан нь ихээхэн шуугиан тарьж байлаа. Түүнчлэн мөргөлдөөн эхэлсний дараахан буюу 2022 оны 03

дугаар сарын есний өдөр Британийн Кардиффын филармони Петр Ильич Чайковскийн “1812” увертюраг урийн сангаасаа хасах шийдвэр гаргаж байлаа<sup>28</sup>. Энэ хөгжмийг одоо тоглох нь зохисгүй гэж үзсэний улмаас ийм шийд гаргаж байв.

Ийхүү дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн сонгодог зохиолчдын бүтээлийг үл хайхрах үзэгдэл газар авсны зэрэгцээ одоо нэр алдраа цуурайтуулж яваа уран бүтээлчид ихээхэн хямралд орсон юм.

Дэлхийн өвд оруулсан ОХУ-ын соёлын хувь нэмэрийг мартуулах, бууруулах гэсэн барууныхны оролдлого нь улс төржсөн сэдэлтэй, олон нийтийн шударга хэрэгцээтэй ямар ч холбоогүй байсан гэж ОХУ-ын ГХЯ-ны Олон улс судлалын хүрээлэнгийн Л.Р.Рустова, Д.Г.Иванова нарын судлаачид “Оросыг чиглэсэн татгалзах соёл ба түүнтэй тэмцэх аргууд” өгүүлэлд үзсэн<sup>29</sup> байдаг.

#### 2.4. Мөргөлдөөний үед орос, украин хэлэнд нэвтэрсэн шинэ үг, хэллэг

ОХУ-Украины мөргөлдөөнөөс үүдэлтэй тус улс дахь улс төр болон нийгмийн нөхцөл байдалд гарсан хурдацтай, мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь цэргийн шинэ нэр томъёо, үг хэллэг үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд эдгээрээр дамжуулан шинэ бодит байдлыг дүрслэн хэлэх болсон юм.

Эдгээр шинэ үг хэллэгүүдийг дотор нь:

1. Цэргийн хэллэг
  2. Этгээд хэллэг
  3. Дайсныг гутаах үг хэллэгүүд гэж хувааж үзэж болохоор байна
- А. Орос хэлэнд нэвтэрсэн шинэ үг, хэллэг*

Орос хэлэнд үүссэн шинэ үг хэллэг ОХУ-ын дээд удирдлага, албан тушаалтнуудын яриа, мэдэгдэл, цэргийн тоймч, улс төрчдийн яриа, улс

<sup>28</sup> “Кардиффская филармония отказалась исполнять увертюру Чайковского ‘1812’.” *RIA Novosti*, March 9, 2022. <https://ria.ru/20220309/chaykovskiy-1777375806.html>

<sup>29</sup> Л. Р. Рустамова and Д. Г. Иванова, “«Культура отмены» в отношении России и способы борьбы с ней,” *Вестник Российского университета дружбы народов*. Серия: Политология 25, no. 2 (2023): 434-444.

төрийн ток шоу, олон нийтийн сүлжээн дэх нийтлэлүүдэд иххээр хэрэглэгдэх болсон. ОХУ-ын медиа орон зайд хамгийн өргөн хүрээнд дэлгэрсэн неологизм буюу шинэ үг хэллэг нь “Цэргийн тусгай ажиллагаа” гэх холбоо үг болж байна. Энэ үгийг анх Владимир Путин 2022 оны хоёрдугаар сарын 24-ний өдөр ард түмэндээ хандсан мэдэгдэлдээ “Цэргийн тусгай ажиллагаа эхлүүлэх шийдвэр гаргасан” гэж онцолсноор цааш энэ үгийг хэрэглэх болсон юм<sup>30</sup>.

Албаны этгээдүүд, төрийн хэвлэлүүд, Украинд өрнөж буй үйл явдал дээр ОХУ-ын алхмыг зөвтгөдөг хүмүүс өнөөгийн мөргөлдөөнийг “цэргийн тусгай ажиллагаа” гэх шинэ үг хэллэгээр томъёолдог болсон.

Улс төр болон эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийн эринд аливаа хэлэнд ихээхэн өөрчлөлт гарч байдаг. ОХУ-ын тухайд ч мөн адил. ОХУ-ын түүхэнд Октябрын хувьсгал, ЗХУ үүссэн, хамтрал, Аугаа их эх орны дайн, түүний үр дагавар, технологийн хөгжил, 50-60-аад оны үсрэнгүй хөгжил, 1990-ээд оны үеийн ЗХУ задран унаснаас үүдэлтэй улс төр, эдийн засгийн өөрчлөлтүүд орос хэлэнд ул мөрөө үлдээж, албан болон ахуйн ярианд ихээхэн өөрчлөлт орж байв. Тухайлбал ЗХУ задран унасны дараа албан болон албан бус хэл, олон нийтийн болон хувь хүний хэл ярианы хоорондын зааг хязгаар бүдгэрч эхэлсний дээр ихэвчлэн англи хэлнээс

зээлдсэн шинэ үг хэллэгүүд орж ирж байлаа. Үүний адилаар Украины эсрэг түрэмгийлэл ч орос хэлэнд багагүй шинэ хэллэгүүдийг оруулж ирсэн юм.

Шинэ үг хэллэг гэдгийг хэрхэн тодорхойлж байна вэ гэсэн асуулт эндээс гарч ирнэ. Найруулга зүйн онолын үүднээс неологизм буюу шинэ үг хэллэг нь тухайн хэлээр ярьж буй хүн шинэлэг талын нөлөөг мэдэрч буй үг хэллэг юм. Зөвлөлтийн эрдэмтэн А.В. Калинин 1966 онд тодорхойлсноор шинэлэг байдлын мэдрэмж нь шинэ үг хэллэгийн цорын ганц шалгуур бол хэл шинжээч Е.В.Сенькогийн үзсэнээр шинэ үг хэллэг нь өвөрмөц, шинэлэг, өргөн хэрэглээнд хараахан нэвтрээгүй гэсэн үзүүлэлт нь шинэ үг хэллэгийг тодорхойлно<sup>31</sup>.

Өмнө нь өгүүлсэн, суртал ухуулгад ашиглагдаж байгаа “Зет” үсэг хэл шинжлэл болон социолингвистикийн талаас ихээхэн сонирхол татаж байгаа юм. Орос болон орос хэлний түүхэнд латин цагаан толгойн ердөө ганц үсэг ОХУ-ын нийгэм улс төрийн хэлэнд нөлөөлсөн одоогийнх шиг жишээ олоход бэрх. “Зет” үсэг нь өөрөө фонем буюу үгийн хувьд төдийлөн ач холбогдолгүй хэлний **авиа зүйн системийн дууны хамгийн бага нэгж** бол одоо хэрэглэгдэж байгаа үгс дээр нэмэгдэхээрээ ач холбогдолтой, хүчтэй утга оруулж буй бүтээвэр болж байна.

<sup>30</sup> ИТАР-ТАСС. “Путин объявил о начале специальной военной операции на Украине.” February 24, 2023. <https://tass.ru/politika/13825671>

<sup>31</sup> Taneli Dobrowolski. Russian Militarization of Memory: The Use of WWII Memory in Russian Politics, Master's Thesis, Tampere University, 2022. <https://trepo.tuni.fi/bitstream/handle/10024/148164/DobrowolskiTaneli.pdf?sequence=2&isAllowed=y>

*Хүснэгт 1. Орос хэлэнд нэвтрэн хэрэглэгдэж буй цэргийн шинэ үг хэллэг*

Үг, хэллэг	Орчуулга
• Антинародная хунта	Ард түмний хунт
• Анти-Россия	ОХУ-ын эсрэг
• Ватник	ОХУ-ын дэглэмийг дэмжигч
• Западные коллеги	Барууны нөхөд
• Западные партнеры	Барууны түнш
• Киевский режим	Киевийн дэглэм
• Киевская хунта	Киевийн хунт
• Киевские власти	Киевийн эрх баригчид
• Коллективный запад	Үгссэн барууныхан
• Колорад	Орос хэлтэй иргэдийг илэрхийлж буй доромж утга
• Крайние националисты	Хэт үндсэрхэг үзэлтнүүд
• Мордор	Сүүдрийн улс
• Нацики	Үндсэрхэг үзэлтнүүд
• Неонацисты	неонацистууд
• Оккупант	Эзлэн түрэмгийлэгч
• Орки	Оркууд
• Правящий на территории Украины режим	Украины нутаг дээр эрх барьж буй дэглэм
• Укроп	Гоньд. Украины зэвсэгт хүчний ажиллагаанд оролцож буй, Украиныг дэмжигч хүн
• Укрофашист	Украины фашист
• Баба-яга	Дрон

*Тайлбар: Эдгээр шинэ үг хэллэгийг зохиогч хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс шүүн оруулсан болно.*

*Б. Украин хэлэнд нэвтэрсэн шинэ үг, хэллэг*

Мөргөлдөөн эхэлснээс хойш украин хэлэнд ч мөн адил шинэ үг хэллэг олноор нэвтрэн хэрэглэгдээд байна. Украинчуудын өдөр тутмын хэл ярианд цэргийн этгээд хэллэгүүд нэвтэрч, шинэ үгс үүсч, энэ явц үргэлжилсээр байгаа аж.

Цэргийн албан хаагчид ашигладаг үгс урьд өмнө энгийн иргэдийн ярианд хэдийн орсон байсан ч, ОХУ, Украины мөргөлдөөн хурцдах үед харьцангуй

олноор, идэвхтэй нэвтэрчээ. Зөвлөлт-Афганы дайны үеэс л бий болсон үгс дахин хэрэглэгдэх болсон буюу тухайлбал, “200”, “300” гэх талийгаач болон шархагдсдыг хэлдэг үгсээс үйл үг үүсэж “хоёр зуудах”, “гурван зуудах” буюу устгагдах, шархдах гэх утгыг илэрхийлэх болжээ.

Дайны нөхцөлд сөргөлдөгч талууд нөгөө талаа гутаан доромжлох үг хэллэг ашиглах нь мэдээж хэрэг. Украинчуудын ярианд ч ийм үг хэллэг



*Хүснэгт 2. Украин хэлэнд нэвтрэн хэрэглэгдэж буй цэргийн шинэ үг хэллэг*

Үг, хэллэг	Тайлбар
• арта	артиллер; артиллерчид
• бандеромобиль	сайн дурынхны өөрсдөө нэмэлтээр тоногдсон, Украины зэвсэгт хүчинд зориулсан автомашин
• байрактарить, энлоить, джавелинить, стингерить, хаймарсить	“Байрактар”-аар устгах/цохих, ПЗРК/ПТРК-аар цохих, HIMARS-аар цохилт өгөх гэх мэт (зэвсгийн нэрсээс үүссэн үйл үгс)
• дискотека	байлдааны ажиллагаа; хүчтэй буудлага, бөмбөгдөлт
• зеленка	бут, сөөг, ой мод ихтэй “ногоон” бүс
• ленточка	“тууз” - цэргийн техникийн урт цуваа/ автоколонн
• мамковать	амь насаа хамгаалж, эрсдэлтэй боловч “энгийн” алхмыг хийхээс зайлсхийх, болгоомжлон үйлдэх
• минус (уходы)	сөргөлдөгчийн чиглэлд харвасан “гарч буй” сум/ пуужин; мөн “минус” - дайсны хохирол гэсэн утгатай хэрэглэгддэг
• минусовать	дайсныг устгах, хохиролд оруулах (“минус болгох”)
• мопед	Ираны камикадзе дрон (ж.ш. Shahed)–ыг хочлон хэлэх нэр
• прилет / приход / смс-ка	дайсны пуужин/сумын “онолт”, газардалт; “смс-ка” - жижиг онолт/богино мэдэгдэл мэт цохилтыг егөөдсөн нэршил
• пиксель, цифра	Украины армийн дижитал хэвлэмэл (“пиксель”) дүрэмт хувцас
• призрак Киева	“Киевийн сүнс” - Украины домогт байлдааны нисгэгчийн тухай домог
• передок	фронтын шугам, хамгийн урд хэсэг
• птичка	“шувуухай” - нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV/БПЛА)

*Тайлбар: Эдгээр шинэ үг хэллэгийг зохиогч хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс шүүн оруулсан болно.*

олноор гарч ирсэн юм. Тухайлбал ОХУ-ын “мордор” эсвэл “оркостан”, ОХУ-ын армийг “оркууд” гэж нэрлэх болсон. Араатны зэрлэг шинж байдалтай зэрлэг бүдүүлэг амьтныг нэрлэдэг энэ нэршил анх Английн зохиолч Ж.Толкины “Бөгжний эзэн”

зохиолд гардгаараа олны дунд тархсан юм.

Түгээмэл хэрэглэгдэж буй бусад үгс:

- **аналоговнет** – /орлуулашгүй/ үнэн хэрэгтээ огт үр дүнгүй төгс боловсруулалт

- **адиннaрот** – /нэг ард түмэн/ Украин улсыг устгаж буйгаа зөвтгөдөг ОХУ-ын үйл ажиллагааг элэглэсэн хэллэг
- **бавовна** – /хөвөн/ Оросууд хяналтаа тогтоосон нутаг дэвсгэрт гарсан дэлбэрэлт
- **затридня** – /гурван өдрийн дотор/ төлөвлөсөн хугацаанд ялалт байгуулна гэх оросуудын төлөвлөгөө, бүтэшгүй амлалт
- **рашка, расея, кацапня** – ОХУ-ыг нэрлэж буй доромж үгс
- **привези унитаз** /суултуур авчрах/ - ОХУ-ын цэргүүдийн дээрэм тонуулыг илэрхийлэх үгс
- **бандеровский смузи** – “Молотовын коктейл”-ын украин нэршил
- **макронить** – /макрондах/ Сүрхий зовнисон царай гаргасан ч үнэндээ юу ч хийхгүй байх гэсэн утгыг илэрхийлэх болсон. Энэ нь Францын Ерөнхийлөгч Эммануэл Макронтой холбоотой бөгөөд дайны эхний үед ихээхэн санаа зовниж байгаагаа илэрхийлсэн ч бодит байдал дээр төдийлөн туслаагүй тул ийм хэллэг үүсэх шалтгаан болжээ. Түүнчлэн энэ үгээр утсаар дэмий чалчих гэсэн утгыг илэрхийлж байна.
- **валять шольца** – /шольц царайлах/ Байнга амласан ч бодит байдал дээр огт туслахгүй байхыг энэ үгээр илэрхийлж байна. Германы канцлер Олаф Шольц шийдэмгий бус байдал гаргаж байгаагийн улмаас Украинд нийлүүлэх зэвсэг шуурхай ирж чадахгүй байгаатай холбоотойгоор ийм хэллэг үүсчээ.
- **шойгунить** – /шойгудах/ бүх зүйл төлөвлөгөөний дагуу явж байгаа гэж итгүүлэх. Энэ нь ОХУ-ын Батлан хамгаалахын сайд Сергей Шойгутай холбоотой гарсан үг юм.
- **кадырить** – /кадырдах/ Мөрөөдлөө бодит мэт ярих. Чеченийн тэргүүн Украиныг эзлэх амбицтай мэдэгдэл нэг бус удаа хийж, тулаан явагдаж байгаа мэт хуурамч бичлэг удаа дараа тавьж байснаас энэ хэллэг үүсчээ.

### В. Улс төрийн шинэ үг хэллэг

Улс төр болон тодорхой улс төрчидтэй холбоотой цэргийн шинэ үг хэллэг ч олноор гарсан. Тухайлбал ОХУ-ын үзэл суртлын үндэс, улс төрийн дэглэмийг ерөнхийд нь “рашизм” гэж нэрлэх болсон юм. Энэ ойлголтод их гүрний дээрэнгүй үзлээс эхлээд фашизмын нэг утгыг ч багтааж байгаа.

Нийгмийн сүлжээнд фашизмыг ОХУ-тай холбож нэрлэх болсноос үүдээд Путин болон Гитлер гэсэн хоёр овгийг нийлүүлэн, “Путлер” гэж ярих болсон нь ОХУ-ын Ерөнхийлөгчид украинчууд хэрхэн хандаж байгааг илтгэнэ.

Тухайлсан бусад улс орнуудын улс төрчидтэй холбоотой хэд хэдэн шинэ үг хэллэг ард түмний дунд гарсныг танилцуулбал:

Эдгээр хэллэгүүдэд үндэслэн дүгнэхэд, шинэ үг хэллэг нь

ойролцоогоо арван жил орчмын хугацаанд хуучирдаг гэж хэл шинжлэлчид үздэг. Эндээс үзэхэд, ОХУ, Украины мөргөлдөөний үеэр үүссэн

шинэ үг хэллэг нь 2035 он хүртэл хэл ярианд ашиглагдаж, утга нь хувьсах магадлалтай байгаа юм.

### Гурав. Дүгнэлт

ОХУ, Украины мөргөлдөөн нь XXI зууны дайн судлалд гарч ирсэн шинэ ойлголт болох гибрид дайны сонгомол жишээ болж байна. Энэ дайнд соёл нь зэвсэгт ажиллагаатай зэрэгцэн өрнөсөн тэмдэг, бэлгэдлийн дайралт, урлагаар дамжсан суртал ухуулга, татгалзах соёл, шинэ үг хэллэгийн (неологизмын) хурдацтай түгээлт нь хоёр улсын нийгмийн төсөөлөл, улс төрийн байр суурь, үнэт зүйлийн гүн туйлшралыг бий болгох стратегийн хэрэгслүүд болж хувирч байна. Уг дайн буюу зэвсэгт мөргөлдөөнийг төлөөлсөн үсгэн бэлгэдлүүдийн хэрэглээ нь (Z, V, O) богино хугацаанд улс төрийн идеологийн тодорхой тэмдэг болон тогтож, нийгмийн дотоод мобилизаци, дайн өдөөгч талаас дайныг зөвтгөх ухуулгын гол элемент болсон бол нөгөө талд Украины зүгээс гаргаж буй урлагийн олон салбар дахь бүтээлүүд тус улсын эсэргүүцэл, нийтийн эв нэгдлийн бэлгэдэл болж, бусад улс орнуудаас дэмжлэг авахад хүчтэй нөлөөлөв. Урлаг, тэр дундаа дуу хөгжим, кино, утга зохиолын салбарт өрнөж буй сөргөлдөөн нь гибрид дайнд соёл бие даасан талбар болж, улс төрийн нөлөөллийн өрсөлдөөн уламжлалт хүчний үйл ажиллагаанаас

үл хамааран үргэлжилж буйг харуулж байна.

Хэл шинжлэлийн түвшинд хоёр талд зэрэгцэн үүссэн шинэ үг хэллэг, улс төрийн неологизм, дайсныг гутаасан нэршлүүд нь нийгмийн ухамсар дахь туйлшралыг эрчимжүүлж, мөргөлдөөний мэдээлэл-сэтгэлзүйн хэмжээсийг тодорхойлох нэгэн гол үзүүлэлт болж байна. Эдгээр үг хэллэгийн хэрэглээ ойрын арван жилдээ үргэлжлэх төлөвтэй бөгөөд дайны талаарх түүхэн ой санамжид ул мөрөө үлдээх магадлалтай юм.

Ийнхүү соёлын талбар нь гибрид дайнд дагалдах нэгэн үзэгдэл гэхээсээ илүү дайтагч талуудын улс төрийн нөлөөний хэрэгсэл болж, улс хоорондын зөрчил, мөргөлдөөн зөвхөн фронтын шугам дээр бус, нийгмийн ухамсар, танин мэдэхүйн орчинд зэрэгцэн өрнөж байна хэмээн үзлээ. Цаашид соёлын бодлого, мэдээллийн аюулгүй байдал, нийгмийн дархлаа зэрэг чиглэлүүд гибрид дайны нөхцөлд улс орнуудын аюулгүй байдлын салшгүй бүрэлдэхүүн хэвээр байх бөгөөд ОХУ-Украины мөргөлдөөн нь соёлын фронт буюу соёлын талбарын үүргийг шинээр тодорхойлж байна.

**Ном зүй / References:**

1. Аюулгүй байдал судлалын хүрээлэн. *Мэдээллийн дайн буюу сэтгэцэд нөлөөт үйлчлэл (Гадаадын цэрэг, тусгай албадын зарим үйл ажиллагаа ба аюулгүй байдлын тулгамдсан асуудал)*. May 15, 2020. <https://niss.gov.mn/мэдээллийн-дайн-буюу-сэтгэцэд-нөлөөт/>.
2. Аюулгүй байдал судлалын хүрээлэн. “Холимог дайны концепц – мэдээлэл сэтгэлзүйн талбар дахь холимог дайн (I).” October 4, 2024. <https://niss.gov.mn/холимог-дайны-концепц-мэдээлэл-сэтгэ/>.
3. BBC Russian. “Переброска войск, поставки оружия и эвакуация из посольств. Как развивается ‘украинский кризис’.” January 24, 2022. <https://www.bbc.com/russian/news-60077654>.
4. Bellingcat. Toler, Aric. “Identifying the Russian Invasion Force.” February 23, 2022. <https://www.bellingcat.com/news/2022/02/23/identifying-the-russian-invasion-force/>.
5. Dobrowolski, Taneli. *Russian Militarization of Memory: The Use of WWII Memory in Russian Politics*. Master’s Thesis, Tampere University, 2022. <https://trepo.tuni.fi/bitstream/handle/10024/148164/DobrowolskiTaneli.pdf>.
6. Dixon, Robyn. “The Letter ‘Z’ Has Become a Symbol of Russia’s War.” *The Washington Post*, March 9, 2022. <https://www.washingtonpost.com/world/2022/03/09/letter-z-russia-symbol-pro-war/>.
7. “How ‘Z’ Became a Symbol for Supporting Russia’s Invasion of Ukraine.” *The Washington Post*, March 9, 2022.
8. ИТАР–ТАСС. “Путин объявил о начале специальной военной операции на Украине.” February 24, 2023. <https://tass.ru/politika/13825671>.
9. Ковалев, Алексей. “Буква Z — официальный (и зловещий) символ российского вторжения в Украину.” *Meduza*, March 15, 2022. <https://meduza.io/feature/2022/03/15/bukva-z-ofitsialnyy-i-zloveschiy-simvol-rossiyskogo-vmorazheniya-v-ukrainu>.
10. Meduza. “Марафон ‘За Россию’ обошёлся почти в 100 миллионов рублей из бюджета.” May 11, 2022. <https://meduza.io/feature/2022/05/11/marafon-za-rossiyu-oboshelsya-pochti-v-100-millionov-rublej-iz-byudzheta-ego-organizoval-ekspertnyy-institut-dalekiy-ot-shou-biznesa-no-blizkiy-k-kremlyu>.
11. Мягкий, Виталий. “Историк рассказал об истинном значении букв Z и V для России.” *URA.RU*, March 17, 2022. <https://ura.news/news/1052539321>.
12. Мягмардорж, П. “Орчин цагийн олон улсын харилцаа ба ‘Гибрид дайн’-ы талаар хийсэн судалгаа, үнэлэлт дүгнэлт.” *Олон Улс Судлал* 46, no. 115 (2023): 12–27. <https://doi.org/10.5564/jis.v46i115.2686>.
13. Моика78. “Певец Олег Газманов отрицает получение 17 млн рублей за каталог патриотических песен.” February 4, 2023. <https://moika78.ru/news/2023-02-04/852047-pevets-oleg-gazmanov-otritsaet-poluchenie-17-mln-rublej-za-katalog-patrioticheskikh-pesen/>.

14. RIA Novosti. “Сборник ‘Z’ представили в Луганске.” May 11, 2023. <https://ria.ru/20230511/sbornik-1871098248.html>.
15. “Кардиффская филармония отказалась исполнять увертюру Чайковского ‘1812’.” March 9, 2022. <https://ria.ru/20220309/chaykovskiy-1777375806.html>.
16. RT на русском. Юта [Анна Владимировна Осипова]. “Премьера песни: «За жизнь».” November 29, 2022. <https://russian.rt.com/russia/video/1080146-premera-pesni-yuta-za-zhizn>.
17. RTVI. “Искусство без ненависти: Как конфликт России и Украины отразился в культуре обеих стран.” <https://rtvi.com/stories/iskusstvo-bez-nenavisti-kak-konflikt-rossii-i-ukrainy-otrazilysya-v-kulture-obeih-stran/>.
18. Roth, Andrew. “Russian Court Jails Man for Replacing Price Tags with Antiwar Messages.” *The Guardian*, April 8, 2022. <https://www.theguardian.com/world/2022/apr/08/russian-court-jails-antiwar-messages>.
19. Рустова, Л. Р., и Д. Г. Иванова. “Культура отмены в отношении России и способы борьбы с ней.” *CyberLeninka*. <https://cyberleninka.ru/article/n/kultura-otmeny-v-otnoshenii-rossii-i-sposoby-borby-s-ney/viewer>.
20. Schogol, Jeff. “Here’s What Those Mysterious White ‘Z’ Markings on Russian Military Equipment May Mean.” *Task & Purpose*, March 9, 2022. <https://taskandpurpose.com/news/russian-military-equipment-white-markings/>.
21. Strategic Studies Institute of National Security Council of Mongolia. *Стратеги тойм №16: Сүүлийн үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, онцлог*. Ulaanbaatar, 2023.
22. Walker, Shaun. “Russia’s War Symbol ‘Z’ Fades from Public View.” *The Guardian*, January 16, 2023. <https://www.theguardian.com/world/2023/jan/16/russia-war-symbol-z-fades-from-public-view>.
23. Khlyvnyuk, Andriy. “Ой у лузі червона калина (Oh, the Red Viburnum in the Meadow).” Instagram video, February 27, 2022. <https://www.instagram.com/p/Cae5TydPAxh/>

## The Cultural Dimension of Hybrid Warfare: The Case of Russia-Ukraine War

***Munkhtsetseg Buyan-Erdene***

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia  
bmunkhtsetseg@mas.ac.mn*

***Abstract:*** *The armed conflict between Russia and Ukraine that began in 2022 represents a comprehensive manifestation of hybrid warfare, in which traditional military operations are combined with information warfare, cultural influence, and other multidimensional instruments. This article examines the mechanisms unfolding in the cultural and artistic spheres within the context of the conflict, including the use of symbolic letters such as “Z,” “V,” and “O” that have come to represent the war, propaganda disseminated through art, and the phenomenon of “cancel culture” directed against Russia. The study also explores the sociolinguistic meaning of newly emerged expressions in Russian and Ukrainian that have developed under the influence of the conflict. Drawing on recent research findings on the concept of hybrid warfare, the paper concludes that the cultural sphere has become an independent mechanism of political influence within hybrid warfare, deepening cultural polarization and confrontation in both countries’ domestic and external environments.*

***Keywords:*** *Russia, Ukraine, hybrid war, culture, cancel culture*

<i>The day of submission:</i>	<i>2025.09.30</i>
<i>Completion of review:</i>	<i>2025.10.28</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2025.11.14</i>